

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/309/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: [rsamongolia@gmail.com](mailto:rsamongolia@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл.....
  - 4.2 Материаллаг байдал.....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/183  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 7 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 81,1 хувиар хэрэгжүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

019020418

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>79,626,047.28</b>	<b>96,147,602.88</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	47,058,609.28	59,777,664.88
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	47,058,609.28	59,777,664.88
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	47,058,609.28	59,777,664.88
31211	Төрийн сангийн харилцах	47,058,609.28	59,777,664.88
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	32,567,438.00	36,369,938.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	961,500.00	749,500.00
35130	Эм боох материал	961,500.00	749,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	31,605,938.00	35,620,438.00
35410	Бичиг хэргийн материал	813,090.00	1,201,190.00
35420	Аж ахуйн материал	583,750.00	583,750.00
35440	Түлш, шатах тослох материал	2,971,200.00	00.00
35460	Хүнсний материал	694,800.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	26,543,098.00	33,835,498.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>437,337,853.96</b>	<b>431,702,803.65</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	437,337,853.96	431,702,803.65
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	429,167,853.96	423,532,803.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	438,163,707.00	448,163,707.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-43,514,022.46	-54,100,861.42
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,985,736.70	23,014,736.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,049,762.47	-10,685,054.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,891,025.10	40,827,305.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,702,709.91	-25,080,909.08
39217	Ном	1,393,880.00	1,393,880.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,170,000.00	8,170,000.00
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,170,000.00	8,170,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>516,963,901.24</b>	<b>527,850,406.53</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>220,887.12</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	220,887.12	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	220,887.12	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	220,887.12	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>516,743,014.12</b>	<b>527,850,406.53</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	516,743,014.12	527,850,406.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	126,536,193.00	126,536,193.00
51101	Өмч: - төрийн	126,536,193.00	126,536,193.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	267,823,435.34	278,930,827.75
51210	Өмнөх үеийн үр дүн	267,823,435.34	267,823,435.34
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	11,107,392.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	122,383,385.78	122,383,385.78
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>516,963,901.24</b>	<b>527,850,406.53</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>288,347,450.00</b>	<b>303,890,480.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,644,650.00</b>	<b>18,141,680.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	13,644,650.00	18,141,680.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>274,702,800.00</b>	<b>285,748,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	238,281,900.00	269,181,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	238,281,900.00	269,181,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,854,300.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,854,300.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	32,566,600.00	16,567,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,566,600.00	16,567,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>241,672,433.53</b>	<b>292,783,087.59</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>241,672,433.53</b>	<b>292,783,087.59</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	237,284,789.53	290,930,918.20
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	156,609,036.00	194,257,942.79
210101	Үндсэн цалин	119,576,381.00	147,651,860.83
210102	Нэмэгдэл	28,926,576.00	37,999,610.56
210104	Урамшуулал	8,106,079.00	8,606,471.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,191,297.84	24,672,232.49
210201	Тэтгэврийн даатгал	13,977,159.63	16,916,250.72
210202	Тэтгэмжийн даатгал	1,555,392.50	1,941,617.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,244,313.94	1,553,294.19
210204	Ажилгүйдлийн даатгал	303,643.05	377,834.35
210205	Эрүүл мэндийн даатгал	3,110,788.72	3,883,235.49
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,579,008.00	18,911,830.61
210301	Гэрэл, цахилгаан	4,436,408.00	5,892,730.61
210302	Түлш, халаалт	9,001,600.00	13,019,100.00
210303	Цэвэр, бохир ус	141,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	1,443,450.00
210401	Бичиг хэрэг	00.00	993,200.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	308,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	142,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23,807,105.00	25,058,610.00
210502	Хоол, хүнс	23,807,105.00	25,058,610.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,000,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	390,000.00	450,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	390,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,708,342.69	25,636,852.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,316,862.00	4,642,122.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,072,700.00	394,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,318,780.69	20,600,330.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,387,644.00	1,852,169.39
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,750,800.00	1,851,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,550,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	1,851,800.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	636,844.00	369.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	636,844.00	369.39
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>46,675,016.47</b>	<b>11,107,392.41</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	2,303,200.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,303,200.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-2,303,200.00	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>44,371,816.47</b>	<b>11,107,392.41</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>274,702,800.00</b>	<b>285,748,800.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>274,702,800.00</b>	<b>285,748,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	238,281,900.00	269,181,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	238,281,900.00	269,181,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,854,300.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,854,300.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	32,566,600.00	16,567,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,566,600.00	16,567,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>227,644,190.72</b>	<b>273,029,744.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>227,644,190.72</b>	<b>273,029,744.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>223,256,546.72</b>	<b>271,177,575.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	156,484,849.00	194,478,829.91
210101	Үндсэн цалин	119,452,194.00	149,728,084.73
210102	Нэмэгдэл	28,926,576.00	36,194,273.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	8,106,079.00	8,556,471.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,094,597.72	24,672,232.49
210201	Тэтгэврийн даатгал	13,880,459.51	16,916,250.72
210202	Тэтгэмжийн даатгал	1,555,392.50	1,941,617.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,244,313.94	1,553,294.19
210204	Ажилгүйдлийн даатгал	303,643.05	377,834.35
210205	Эрүүл мэндийн даатгал	3,110,788.72	3,883,235.49
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,322,958.00	16,067,130.61
210301	Гэрэл, цахилгаан	4,436,408.00	5,892,730.61
210302	Түлш, халаалт	9,745,550.00	9,974,400.00
210303	Цэвэр, бохир ус	141,000.00	200,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	103,500.00	00.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23,514,800.00	24,363,810.00
210502	Хоол, хүнс	23,514,800.00	24,363,810.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	390,000.00	450,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	390,000.00	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,845,842.00	10,645,572.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,595,842.00	8,936,272.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	1,709,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,387,644.00</b>	<b>1,852,169.39</b>

2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,750,800.00	1,851,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,550,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	1,851,800.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	636,844.00	369.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	636,844.00	369.39
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>47,058,609.28</b>	<b>12,719,055.60</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	47,058,609.28	12,719,055.60
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	47,058,609.28
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	47,058,609.28	59,777,664.88

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,536,193.00	122,383,385.78	267,823,435.34	516,743,014.12
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,536,193.00	122,383,385.78	267,823,435.34	516,743,014.12
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,536,193.00	122,383,385.78	267,823,435.34	516,743,014.12
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,107,392.41	11,107,392.41
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,536,193.00	122,383,385.78	278,930,827.75	527,850,406.53

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангил	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	316,239,500.00	256,462,244.40	59,777,255.60	81.1
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	316,239,500.00	256,462,244.40	59,777,255.60	81.1
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	314,387,700.00	254,610,444.40	59,777,255.60	81.0
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	240,828,400.00	194,478,829.91	46,349,570.09	80.8
2E+05	Үндсэн цалин	155,208,100.00	149,728,084.73	5,480,015.27	96.5
2E+05	Нэмэгдэл	77,884,300.00	36,194,273.78	41,690,026.22	46.5
2E+05	Урамшуулал	7,736,000.00	8,556,471.40	-820,471.40	110.6
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,086,300.00	24,672,232.49	5,414,067.51	82.0
2E+05	Тэтгэврийн даатгал	20,458,900.00	16,916,250.72	3,542,649.28	82.7
2E+05	Тэтгэмжийн даатгал	2,407,100.00	1,941,617.74	465,482.26	80.7
2E+05	ҮОМШӨ-ний даатгал	1,925,200.00	1,553,294.19	371,905.81	80.7
2E+05	Ажилгүйдлийн даатгал	481,200.00	377,834.35	103,365.65	78.5
2E+05	Эрүүл мэндийн даатгал	4,813,900.00	3,883,235.49	930,664.51	80.7
2105	<b>Нормативт зардал</b>	31,232,900.00	24,363,810.00	6,869,090.00	78.0
2E+05	Хоол, хүнс	31,232,900.00	24,363,810.00	6,869,090.00	78.0

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	569,800.00	450,000.00	119,800.00	79.0
2E+05	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	569,800.00	450,000.00	119,800.00	79.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11670300.00	10645572.00	1,024,728.00	91.2
2E+05	Бараа үйлчилгээний бусад зардал	9,961,000.00	8,936,272.00	1,024,728.00	89.7
2E+05	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,709,300.00	1,709,300.00	00.00	100.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1851800.00	1851800.00	00.00	100.0
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,851,800.00	1,851,800.00	00.00	100.0
2E+05	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,851,800.00	1,851,800.00	00.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	314,666,900.00	269,613,000.00	45,053,900.00	85.7
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	314,666,900.00	269,613,000.00	45,053,900.00	85.7
1E+05	Улсын төсвөөс санхүүжих	314,666,900.00	269,613,000.00	45,053,900.00	85.7
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	47,058,609.28	-47,058,609.28	
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	59,777,664.88	-59,777,664.88	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 8 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 81,1 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 14 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 оны 11 сард аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтад хамрагдсан. 93,2 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,886.5 мянган төгрөгөөр буюу 2,0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	47,058.6	59,777.7	12,719.1
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	32,567.4	36,369.9	3,802.50
Үндсэн хөрөнгө	437,337.9	431,702.8	-5,635.05
Нийт хөрөнгө	<b>516,963.9</b>	<b>527,850.4</b>	<b>10,886.51</b>
Өр төлбөр	220.8		- 220.89
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	516,743.1	527,850.4	-11,107.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>516,963.9</b>	<b>527,850.4</b>	<b>10,886.51</b>

/мянган төгрөгөөр/

2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 59,777.7 мянган төгрөг болж мөнгөн хөрөнгө данс 12,719.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цалин болон бусад зардал хэмнэгдсэнтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэл байхгүй.

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 3,802.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн хөгжлийн сангаас 6,000.0 мянган төгрөгийн тоглоом авсан.

Төсвийн хөрөнгөөр 39,059.6 мянган төгрөгийн үнэтэй хангамжийн бараа материал худалдаж авсан. 41,257.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 431,702.8 мянган төгрөг боловч өмнөх оны мөн үеэс 5,635.0 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 299,672.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 16,567.5 мянган төгрөг нийт зарлагыг 316,239.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 316,239.5 мянган төгрөгөөр баталсан байна

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 316,239.5 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 299,672.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 16,567.5 мянган төгрөг нийт 316,239.5 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 256,462.2 мянган төгрөг буюу 81,1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас үндсэн цалин болон нэмэгдэл 47,170.0 мянган төгрөг, хоолны зардал 6,869.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 1,024.7 мянган төгрөг, бүх төрлийн даатгалын зардал 5,414.0 мянган төгрөг тус тус хэмнэсэн.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр

Дансны код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71801	Сургуулийн өмнөх боловсрол	331,300.0	273,029.3	59,888.4	82,4%
81605	Эрүүл мэндийн зардал	984.7	975.0	9.7	99%
81807	Хүүхдийн хоол	29,292.9	23,398.3	5,894.5	79,9%
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,826.6	1,826.6		100%
81823	Багшийн хөгжлийн зардал	1,189.7	1,036.0	153.7	87,1%
81832	Нүүдлийн бүлэг	6,224.0	1,813.7	4,410.2	29,1%
81834	Боловсролын стандарт	175,247.8	139,385.2	35,862.5	79,5%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	101,473.8	88,027.2	13,446.5	86,7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	80111	1-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал 100%	16,567.5	16,567.5
2	81605	9-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Эрүүл мэндийг дэмжих 99%	984.7	975.0
3	81807	1-6, 9-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Цэцэрлэгийн хүүхдийн хоол 79,9%	29,292.9	23,398.3
4	81816	1-6, 9-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Хүүхдэд ээлтэй орчин 100%	1,826.6	1,826.6
5	81823	1-6, 9-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Мэргэжил дээшлүүлэх 87,1%	1,189.7	1,036.0
6	81832	1-6,9-12 сар	Хүүхэд бүрийг хамруулах	Нүүдлийн бүлэгт хамруулах 29,1%	6,224.0	1,813.7
7	81834	1-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Стандарт сургалтын үйл ажиллагаа 79,5%	175,247.8	139,385.2
8	81835	1-12 сар	Үндсэн үйл ажиллагаа	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 86,7%	101,473.8	88,027.2

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хүүхдийн ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн. Нүүдлийн бүлэгт хамруулах арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн. Мэргэжил дээшлүүлэх арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь ээлжийн амралттай холбоотой дутуу хэрэгжсэн. Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэн, ЕБС цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Тендер зарласан боловч оролцох байгууллага байхгүй

учраас шууд худалдан авалтаар худалдан авалт хийсэн. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлвөлгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 11/05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 190,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 3,800.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,040.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 3 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Архуст сумын цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 8 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023

оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 46,349.5 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 6,869.0 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 1,024.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 151 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 8 мэдээлэл хоцроож байршуулсан байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж зөвлөмж өгөв.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн ба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Архуст сумын Хүүхдийн цэцэрлэг нь эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж биелж, 1 зөвлөмж биелэгдээгүй тул албан шаардлага өгөв.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	94.0	1	94.0	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1		1		
Нийт дүн	1	94.0		94.0	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 544.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 544.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

#### 5.2 Албан шаардлага

1.Батлагдсан жишиг нормыг баримталж ажиллаагүйн улмаас 544.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02 өдрийн А/166 дугаартай хамтарсан тушаалын 1- 2 р хавсралт, санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.6-д “Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн холбогдох тушаал зааврыг дагаж мөрдөн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

#### 5.3 Зөвлөмж

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Т	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

			о									
			о									
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүнсний материалыг батлагдсан нормын дагуу бодоогүй	1	544.5			1	544.5						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>544.5</b>			<b>1</b>	<b>544.5</b>						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэнд дансанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 151 мэдээллийг хугацаандаа, 8 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	1						1	
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)